АЗИЙН БА БАРУУН НОМХОН ДАЛАЙН ГЭРЭЭЛЭГЧДИЙН АССОЦИАЦИУДЫН ОЛОН УЛСЫН НИЙГЭМЛЭГ (IFAWPCA)-ИЙН 46 ДАХЬ ЧУУЛГАН НЬ БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА УРИА ДОР ЧУУЛЛАА



Азийн ба Баруун Номхон Далайн Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон Улсын Нийгэмлэг (IFAWPCA)-ийн 46 дахь Чуулган нь Бүгд Найрамдах Балба Улсын нийслэл Катманду хотноо 2023.11.21-25-ны хооронд **“ТОГТВОРТОЙ ДЭД БҮТЦИЙН ТҮНШЛЭЛ”** уриа дор хуралдахдаа цар тахлын дараах улс орнуудын эдийн засгийн нөхцөл байдал, сэргэлт, хүндрэл бэрхшээлийг хэрхэн хамтдаа даван туулах, Засгийн газраас гаргаж буй шийдвэрүүд зэрэг асуудлын хүрээнд санал бодлоо хуваалцан чуулласа. Тус Чуулганыг Балба Улсын Барилгачдын Ассоциациудын Нийгэмлэг (FCAN) нь зохион байгуулж буй бөгөөд тус Нийгэмлэг нь 24,000 гаруй барилгачдыг эгнээндээ нэгтгэсэн, улсынхаа эдийн засгийн хөгжилд идэвхтэй үүргийг гүйцэтгэдэг, Балба



Улсын Засгийн газрыг дэмжин ажилладаг, барилгын салбарын Гэрээлэгчдэд барилгын тусгай зөвшөөрлийг олгох, зуучлах ажлыг зохион байгуулдаг, нөлөө бүхий дээвэр байгууллага, Ерөнхийлөгчөөр нь IFAWPCA-ийн Ерөнхийлөгч Раби Синг сонгогдон ажиллаж байгаа болно.

Тус 46 дахь Чуулганы хүрээнд IFAWPCA-ийн гишүүн орнуудын цуврал хурлууд буюу Санхүүгийн хорооны хурал, Ерөнхийлөгчдийн хурал, Чуулганы нээлтийн үйл ажиллагаа ба Ерөнхий ассамблей-1,2-р хурал, Удирдах зөвлөлийн хурал-1,2,3-р хурал, Байнгын хороодын хурал зохион байгуулагдсан бөгөөд Монгол Улсыг төлөөлж МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Л.Хулан нь эдгээр хурлуудад амжилттай оролцлоо.

Эхний өдрийн арга хэмжээгээр **“САНХҮҮГИЙН ХОРООНЫ ХУРАЛ”** хуралдаж, тус хорооны дарга Оливер Эйч Си Ви даргалж, хурлаар 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2023 оны батлагдсан төсөв, зарцуулалтын дүгнэлт, гишүүн орнуудын 2020-2023 оны гишүүнчлэлийн татвар төлөлтийн байдал, Энэтхэгийн Барилгачдын Холбоо (BAI), Бутаны Барилгын Холбоо (CAB), БНСУ-ын Барилгын Холбоо (CAK) зэрэг холбоодын асуудлыг авч хэлэлцэж, 2024 оны төсвийн төслийг танилцуулан батлууллаа. Мөн энэ хурлаар IFAWPCA-ийн гишүүдийг өргөжүүлэн тэлэх бодлогыг баримталж, “НЭГ САНАА-НЭГ ЧИГЛЭЛ”-ээр ажиллахаар санал нэгдлээ.



“Санхүүгийн хорооны хурал”-ын дараа IFAWPCA-ИЙН гишүүн орнуудын **“ЕРӨНХИЙЛӨГЧДИЙН ХУРАЛ”** зохион байгуулагдаж, энэ хурлаар IFAWPCA-ийн гишүүн орнуудын төлөөллүүд нь дараах мэдээллийг хийлээ. Үүнд:

ШРИ-ЛАНКИЙН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ (NCASL): IFAWPCA бол салбарын тогтвортой хөгжлийг бий болгох гол зорилгоо дэлхийн II дайны дараа тавьсан бөгөөд орчин цагт өөрийн гол зорилгоо хэрэгжүүлэхийн тулд “Авлигатай тэмцэх” асуудлыг дайн хийж байгаатай адил дүйцүүлж болохоор байна. Ковид цар тахлын дараа маш олон салбарууд шинэчлэлийг хийснээр тодорхой хэмжээний ахицыг гаргаж, үйл ажиллагаанууд нь сэргэж байна. Засгийн газрын хувьд хөрөнгө оруулалтын боломжуудыг, оролцоог, эрх тэгш байдлыг хангах орчныг бүрдүүлэх хэрэгтэй байна. Засгийн газар нь хангалттай дэмжлэгийг үзүүлж чадахгүй байгаа хэдий ч тус улсын хувьд эрчим хүчний салбарыг хөгжүүлэхийн тулд шаардлагатай хөрөнгө оруулалтыг 2024 оны төсөвтөө суулгасан. Түүнчлэн, байгаль орчныг бохирдуулахгүй, сүйтгэхгүй байх үүднээс дэмжсэн чиглэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүний хүрээнд Засгийн газар нь Худалдан авалтын эрх зүйн бичиг баримтуудыг шинэчлэн найруулах, батлан хүчин төгөлдөр болгох үйл ажиллагааг тэлэх асуудал дээр анхаарч ажиллаж байна. Барилгын салбарыг шинэ түвшинд гаргахын тулд одоогийн байдлаар цахимжуулах, автоматжуулах, роботжуулах асуудал нь хамгийн ур өгөөжтэй байгаагаас гадна төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтын нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих чиглэлийг баримтлан ажиллахаа илэрхийлэв. Шри-Ланкийн Үндэсний Барилгын Ассоциацийн хувьд ажиллах хүчний хувьд хангалттай байгаа бөгөөд барилгын чиглэлийн сургалтуудыг ихээр хийдэг. Тиймээс мэргэжлийн, ур чадвартай мэргэжилтнүүдийг бэлтгэхэд IFAWPCA-ийн Гишүүн орнуудтай хамтран ажиллаж дэмжлэг үзүүлэх боломжтой байна. Мөн эрчим хүч, зочид буудал, хурдны зам, усан цахилгаан станцыг барих зэрэг асуудал дээр хамтран ажиллахад бэлэн байгаа, гэхдээ хамтран ажиллахын тулд тухайн улсын Засгийн газар, Банк, Хөрөнгө оруулагч нарын хоорондын хамтарсан гэрээг байгуулж хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, баталгааг гаргаж өгөх асуудал дээр маш сайн бодлого, хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн байх ёстойг онцлов.

БАНГЛАДЕШИЙН БАРИЛГЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН АССОЦИАЦИ (BACI): Тус улс нь 2018 оноос эхлэн залуучуудын ур чадварыг хөгжүүлэх, үйл ажиллагааг нэмэгдүүлэх асуудлыг тавьж ирсний үр дүнд Азийн хөгжлийн банкны санхүүжилттэйгээр барилгын чиглэлийн ур чадвартай ажиллах хүчнийг бэлдэх төвийн барилгыг барьж дуусгасан байна. Сүүлийн 15 жилийн хугацаанд гадаадын буюу ЖАЙКА (JICA), Азийн хөгжлийн банк (ADB), Дэлхийн банк (WB), Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн төслүүдийг хэрэгжүүлж байна. Дотоодын хүчин чадал нь тийм өндөр биш ч гаднын улс орнуудын төслүүдийг хэрэгжүүлж байгаа нь эдийн засагт маш их хувь нэмрийг оруулж байна. Азийн хөгжлийн банк (ADB)-аас хэрэгжүүлж буй төслүүд нь гол төлөв ур чадварыг бий болгох сургалтууд байдаг бөгөөд хүний нөөцийн чадавхыг сайжруулан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар тус улсын хүн амын 60 хувь нь ажиллах хүчний боломжтой хүн амаас бүрдсэн байгаагаас 20 хувь нь залуучууд байна. Мөн Япон, Тайланд, Солонгос, Индонез улсуудын логистик, тоног төхөөрөмжийн дэмжлэгийг үзүүлсэн төслүүд ч тус салбарт хэрэгжиж байгаа нь эдийн засагт ихээхэн дэмжлэгийг үзүүлж байна. Мөн барилгын материалын хувьд жонш шохойг Энэтхэг, Хятад, Дундад азийн улсуудаас импортолж байгаа тул энэ чиглэлээр өөр орнуудтай бас хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа дурдав.



ИНДОНЕЗИЙН ГЭРЭЭЛЭГЧДИЙН АССОЦИАЦИ (ICA): Гишүүн байгууллагуудын дунд сургалтын чиглэлээр тэр дундаа онлайн сургалтуудыг хамтран зохион байгуулан ажиллах сонирхолтой байгаа бөгөөд Барилгын мэдээллийн инженерчилсэн загвар (БИМ)-ын 3 өдрийн сургалтыг хийдэг туршлагатай, энэхүү сургалтыг 2 өдөр нь цахимаар, 1 өдөр нь практик хэлбэрээр явуулдаг гэдгээ онцлов. Мөн инженерүүдийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулдаг. Тэтгэлэг олгох асуудлын хувьд хэцүү байгаа ч “Хүний капиталын хөгжил” нь хамгийн чухал байгаа тул IFAWPCA-г Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага (ILO)-тай хамтран ажиллах асуудлыг ярилцах хэрэгцээ байгааг дурдав (Мэдээллийг слайдаас харах).

МАЛАЙЗЫН МАСТЕР БАРИЛГАЧДЫН АССОЦИАЦИ (MBAM): Хамтран ажиллах гэрээ болон зуучлах асуудлыг Сингапур Улстай адилхан хийдэг бөгөөд барилгын салбар нь 3 хуулийн хүрээнд зохицуулагдаж үйл ажиллагаагаа явуулдаг, харин одоо эдгээр хуулиудыг шинэчлэн найруулах ажил явагдаж байгаа бөгөөд хамгийн гол асуудал нь аж ахуйн нэгжийн зардал болон маргааны төлбөрийг багасгах асуудал дээр ажиллаж байгаа болно.



МБҮА ТББ (MNCA): МБҮА ТББ-ын IFAWPCA-ийн 42 дахь Дунд хугацааны Чуулганы Удирдах зөвлөлийн хурлын үеэр IFAWPCA-ийн гишүүн орнуудын эгнээгээ тэлэх үүднээс Төв Азийн орнуудыг гишүүнээр нэгтгэх нь чухал байгаа тул МБҮА ТББ нь өөрийн Бүгд Найрамдах Узбекистан Улсад дахь Төлөөлөгчөөрөө дамжуулан үүнийг судлуулах боломжтой байгаа санаачилгыг гаргасны дагуу “эдгээр улсууд нь эдийн засгийн хувьд бэлэн бус, судлах хугацаа шаардлагатай байгаа” асуудлыг уламжлав. Мөн МБҮА ТББ нь ФИДИК-д “Түншлэгч гишүүн”-ээр элсэх асуудлыг тавихдаа IFAWPCA болон Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яамны дэмжлэгийг авсан, мөн ФИДИК-ийн гишүүнчлэлд тавьсан холбогдох шаардлагуудыг хангасан тул элсэх эрхийн болзлыг хангасны дагуу 2023.09-р сард батламжлагдсан бөгөөд 2023.11-р сарын сүүлээр ФИДИК-ийн удирдлагуудтай цахим уулзалтыг хийн хэрхэн цаашид хамтран ажиллах асуудлын хүрээнд мэдээллээ солилцох болсон, мөн Монгол Улс нь “Барилгын тухай” хуулиа шинэчлэхээр ажиллаж байгаа талаар мэдээллээ.



Монгол Улс 42 дахь дунд хугацааны Удирдах Зөвлөлийн хурал

БАЛБЫН ГЭРЭЭЛЭГЧДИЙН АССОЦИАЦИ (FCAN): Тус улсын Засгийн газар нь худалдан авах ажиллагааны стратеги дээрээ өөрчлөлт хийхээр ажиллаж байгаа бөгөөд Хонг Конг, Малайз улсуудын хуулиас сайн жишгийг нь оруулахыг санал болгож байна.

ХОНГ КОНГЫН БАРИЛГЫН АССОЦИАЦИ (HKCA): Улс орнуудын хувьд хөрөнгө оруулагчидтай хийх гэрээг тухайн улсын Засгийн газрыг төлөөлөн хийж албажуулдаг, хүчин төгөлдөр болгодог байгууллага байдаг. Гэтэл Засгийн газар, хөрөнгө оруулагчдын хамтын ажиллагаа нь хүн хоорондын харилцаанаас маш их хамаардаг тул ажил удаашрах, урагшлахгүй байх асуудлууд үүсдэг байна. Тиймээс хүн хоорондын харилцаа, хамтран ажиллах арга барил, асуудлыг ойлголцох зүйлсэд анхаарлаа хандуулж ажиллах нь маш чухал байгааг онцлов. Мөн 2024.01-р сард Хонг Конг-д дээрх сэдвийн дагуу арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж байгаа гэв.

СИНГАПУРЫН ГЭРЭЭЛЭГЧДИЙН АССОЦИАЦИ (SCAL): Тус улсын хувьд ажиллах хүчинд тавьж буй шалгуур үзүүлэлтийг нэлээн өндөрсгөж байгаа ба ажилтнуудын зөөлөн ур чадварыг чухалчлахаас



гадна ЧАНАРЫГ илүү эрхэмлэж байгаа. Хэдийгээр ажиллах хүчний асуудал хүндрэлтэй байгаа ч гаднын ажилтнуудыг сургаж, мэдлэгжүүлэхээс гадна аливаа маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд маргааныг шийдвэрлэх чиглэлийн зөвлөх үйлчилгээг Гишүүн байгууллагууддаа үзүүлдэг. Ингэснээр компаниуд нь цаг хугацаа болон эдийн засгийн хувьд хэмнэлтийг бий болгож, үйл ажиллагааныхаа зардлыг багасгахад нь нэмэр болдог байна. Мөн мэргэшсэн инженерүүдийн мэргэжлийг дээшлүүлэх, төслийн удирдлагын менежментийг хэрэгжүүлэх, технологийн сургалтад суралцах асуудлыг өөрийн Академиараа дамжуулан хэрэгжүүлдэг байна. Мөн одоо байгаа Барилгын хуульдаа нэмэлт өөрчлөлтийг оруулах гэж буй нь зардал болон маргааныг багасгахад илүү чухал тул түлхүү анхаарлаа хандуулан ажиллаж байгаа болно.

Мөн IFAWPCA-ийн хувьд Шинэ Зеланд Улсын Барилгын ассоциаци тодорхой бус шалтгаанаар идэвхгүй байгаа тул гишүүнчлэлийн статусыг нь түдгэлзүүлснээр өнөөдрийн байдлаар 18 гишүүн орнуудыг хамруулан үйл ажиллагаагаа явуулж байна. Япон, Солонгос улсуудын барилгын ассоциациуд нь дотоод асуудлын шалтгаанаар идэвх суларсан боловч удахгүй эргэж идэвхжих хандлагатай байгааг дурдав. Иймд урьд өмнө нь ажиглагчаар байсан гишүүн орон буюу Вьетнам, Афганистан улсуудыг идэвхжүүлэх тал дээр ярилцсан ч Вьетнам Улс нь гишүүнчлэлийнхээ татварыг төлөөгүй, дотоодын үйл ажиллагаа нь сул, тухайн орны талаар мэдээлэл муутай байгаа зэрэг асуудал хөндөгдсөн ч Вьетнам Улсын эдийн засаг нь сүүлийн жилүүдэд огцом өсөж, бусад улс орнуудын анхаарлыг зүй ёсоор татаж байгаа тул дахин эргэж холбогдон гишүүнчлэлийн асуудлын тал дээр анхаарах хэрэгтэйг дурдав.

Мөн тус хурлаар Монгол Улсад зохион байгуулагдсан IFAWPCA-ийн 42 дахь Дунд хугацааны чуулганыг МБҮА ТББ нь маш сайн зохион байгуулалтай, амжилттайгаар зохион байгуулсанд нийт IFAWPCA-ийн гишүүн орнуудын өмнөөс IFAWPCA-ийн удирдлагууд дахин баярыг хүргэсэн болно. Үүний дараа Чуулган бүрийг үсгийн дарааллын дагуу хийдэг уламжлалт ёсоор 47 ДАХЬ ЧУУЛГАНЫГ 2025 ОНД СИНГАПУР УЛСАД 2023.04-р сарын эхээр хийх, 48 ДАХЬ ЧУУЛГАНЫГ Шри Ланк-д хийх байсан хэдий ч эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас ТАЙЛАНДАД хийх, 49 ДАХЬ ЧУУЛГАНЫГ ШРИ ЛАНК-Д хийх, харин 50 дахь Чуулганыг Тайванд хийх ёстой байсан боловч БНХАУ-ын Тайван гэсэн асуудлын хүрээнд энэ асуудлын шийдвэрийг Тайваний Ерөнхий Гэрээлэгчдийн Ассоциаци (TGCA) нь эргэж тодорхой хариуг өгөх, 43 ДАХЬ ДУНД ХУГАЦААНЫ ЧУУЛГАНЫГ ТАЙВАНД 2024.10-р сарын дундуур зохион байгуулахаар тогтов.

Удаах асуудал нь IFAWPCA-ийн веб сайтын шинэчлэл, хөгжүүлэлт нь хийгдэж дууссан, цаашдын эзэмшигч нь хэн байх, ямар байгууллага байх, энэ ажлыг NCASL нь хэрхэн IFAWPCA-д хүлээлгэн өгөх зэрэг асуудлаар IFAWPCA нь тодорхой хариуг өгөхгүй байгаа тул энэ асуудлыг шийдэж өгөх талаар гишүүн орнуудын удирдлагуудад танилцуулав. FCAN нь IFAWPCA-ийн 46 дахь Чуулганд зориулсан АПП-ыг хөгжүүлсэн бөгөөд үүнийг IFAWPCA-ийн веб сайттай хэрхэн хооронд нь уялдуулан ашиглах, энэ АПП-ыг ашиглахад IFAWPCA-ийн үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг хурдан шуурхай, чанарын дээд түвшинд авч болох боломжтой байгаа, аюулгүй ажиллагааны үүднээс хүлээж авах эзэмшигчийг хэлэлцэж тогтох нь чухал байгаа зэрэг асуудлыг дурдаж эдгээр асуудлыг дахин сайн судлахаар болов.

Мөн тус хурлаар хамтын өсөлт, хөгжил цэцэглэлтэд тогтвортой замаар хүрэхийн тулд мэдлэг туршлагаа хуваалцах, Гишүүн орнуудын дунд “ТҮНШЛЭЛИЙН ПЛАТФОРМ”-ыг ажиллуулах, хамтран ажиллах асуудал дээр анхаарлаа хандуулан ажиллахаар тогтлоо.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ-I

Тус хурлын нээлтийг IFAWPCA-ийн Ерөнхийлөгч Раби Синг хийж, хурлын хөтөлбөрийг танилцуулсны дараа Монгол Улсад IFAWPCA-ийн 42 дахь Дунд хугацааны чуулганыг амжилттай зохион байгуулсныг сайшаагаад, хурлаар хэлэлцэх асуудал болон хөтөлбөрийг баталж, байнгын хороодоор ямар асуудлыг хэлэлцүүлэхийг эрэмбэлэв. Мөн түүнчлэн, өмнөх хурлаас үүссэн IFAWPCA-ийн сайт, түүний бүтэц, хөгжүүлэлт, IFAWPCA-ийн Чуулганы шинэ эргэлт, 48 дахь Чуулганыг хэрхэн зохион байгуулах зэрэг асуудлыг хэлэлцлээ. Мөн хурлаар IFAWPCA-ийн шинэ Нарийн бичгийн даргыг сонгох, болон хуралд хүрэлцэн ирсэн гишүүн орнуудын Ерөнхийлөгчдийн тайланг сонсох, бие биедээ мэдээлэл өгч, санал солилцох асуудлууд явагдлаа.

Энэ орой нь **IFAWPCA-ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ** РАБИ СИНГХ нь IFAWPCA-ийн гишүүн орнуудын Ерөнхийлөгч болон Тэргүүлэгч удирдлагуудад **“ХҮНДЭТГЭЛИЙН ОРОЙН ЗООГ”**-ийг Балба Улсын эртний түүхтэй зоогийн газар барилаа.


22 Nov 2023 With Foreign Minister Mr Narayan Prakash Saud



Удаах өдөр нь IFAWPCA-ийн 46 дахь Чуулганы **“НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ЕРӨНХИЙ АССАМБЛЕЙ-1”** зохион байгуулагдаж, IFAWPCA-ийн Үндсэн хууль, протоколд оруулсан нэмэлт өөрчлөлт, урьдах хурлын протокол, 2023.06.14-17-ны хооронд Монгол Улсад IFAWPCA-ийн 42 дахь Дунд хугацааны чуулганыг амжилттай зохион байгуулсныг дурдсаны дараа нээлтийг ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН БАЛБА УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ НОЁН РАМ ЧАНДРА ПАУДЕЛ нээж үг хэлсэн бөгөөд тэрээр: “*Азийн ба баруун номхон далайн бүсийн барилгын мэргэжилтнүүдийг нэгэн дээвэр дор цуглуулсан байгууллага болох Азийн ба Баруун Номхон Далайн Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон улсын нийгэмлэг (IFAWPCA)-ийн Хүндэт Ерөнхийлөгч болон Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улсын Засгийн газрын Ерөнхий Сайд, Засгийн газрын өндөр албан тушаалтнууд, IFAWPCA-ийн Хүндэт албан тушаалтнууд, IFAWPCA-ийн Гишүүн орнуудын төлөөлөгчид, Балбын Гүйцэтгэгчдийн Холбооны гишүүд, Хүндэт хадагтай, ноёд оо!*

24,000 гишүүнтэй Балбын Гүйцэтгэгчдийн Холбооноос зохион байгуулж буй Азийн ба Баруун Номхон Далайн Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон улсын нийгэмлэг (IFAWPCA)-ийн 46 дахь





Чуулганд оролцож буй төлөөлөгчид, гишүүд Та бүхэндээ энэ өдрийн халуун мэндийг хүргэе. Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улс нь сүүлийн 24 жилийн хугацаанд 2 дахь удаагаа уг чуулганыг эх орондоо зохион байгуулж байгаад баяртай байна.

Юуны өмнө саяхан Балбын баруун бүс нутагт болсон аймшигт газар хөдлөлтийн улмаас амь насаа алдсан хүмүүсийн гэр бүлд гүнээ эмгэнэл илэрхийлье. Шархадсан болон гэмтсэн хүмүүс хурдан эдгэрч тэнхрэхийг хүсэн ерөөж, гамшгийн энэ хүнд үед эмгэнэл илэрхийлэн тусламжийн гараа сунгасан бүх улс оронд талархлаа илэрхийлье. Аливаа улс орны эдийн засгийн хөгжилд дэд бүтэц чухал үүргийг гүйцэтгэдэг ба дэлхий дахинд уг салбарт томоохон ахиц дэвшлийг гаргасан улс орнуудын эдийн засаг нь төдий чинээгээр ахиц дэвшилттэй байж таардаг билээ. Хэдийгээр дэд бүтцийг хөгжүүлэх нь улс орон бүхэнд чухал боловч үүнээс улбаалан гарч буй бусад үр дагаврууд дээр анхаарах нь чухал байна. Өөрөөр хэлбэл, та бидний амьдарч буй энэ цаг үед өдөр бүр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл нэмэгдэж, үүнээс улбаалан байгалийн гамшгийн тоо нэмэгдэж байгаа тул барилга, дэд бүтцийн салбарт ажиллаж буй хүмүүс нь байгаль орчны сорилтыг даван туулах, шийдвэрлэх арга хэмжээнүүдийг авах ёстой болоод байна. Тиймээс "ДЭЛХИЙ АМЬД БАЙЖ БИД АМЬДАРНА" гэсэн зарчмыг баримталж, БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ нэн тэргүүнд тавихыг энэхүү чуулганд оролцож буй нийт гишүүн байгууллагын төлөөлөгч нар анхааралсай хэмээн хүсэж байна. IFAWPCA-ийн Гишүүн орнуудын хувьд уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшигт өртөмтгий байдаг тул энэ байгууллага нь УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН АСУУДЛЫГ нэн тэргүүнд тавих ёстой гэж би үзэж байна. Тиймээс IFAWPCA-ийн Гишүүн орнуудын нягт хамтын ажиллагааг болон хүчин чармайлтыг дэмжих нь үр дүнтэй бөгөөд маш чухал нөлөөг үзүүлэх юм. Дашрамд дурдахад, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга нь саяхан Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улсад айлчлахдаа уур амьсгалын өөрчлөлтийг хэлэлцэх асуудлын ач холбогдлыг онцлон тэмдэглэснийг Та бүхэнд хэлэх нь зүйтэй болов уу. НҮҮРСТӨРӨГЧИЙН ЯЛГАРЛЫН ХИЙГ БУУРУУЛАХ замаар БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ, ТОГТВОРТОЙ ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨӨ ХАМТРАН АЖИЛЛАХЫГ энэхүү чуулганд оролцож буй Та бүхэнд дахин дахин уриалж байна. Өнөөгийн технологийн эрин зууны ертөнцөд IFAWPCA нь байгууллагын хувьд технологийн дэвшлийг нэвтрүүлэх нь хамтын ажиллагааг улам бэхжүүлж, үйл ажиллагааг нь өргөжүүлэн тэлэхэд хувь нэмрээ оруулна гэдэгт би итгэж байна. Дэлхий нийтээрээ эдийн засгийн хямралтай тэмцэж байгаа энэ цаг үед эдийн засгийн нөхцөл байдлыг дээрдүүлэхэд барилгын бизнес эрхлэгчдийн хувь нэмэр нэн чухал байгаа бөгөөд хямралд орсон эдийн засгийг зөв замд нь оруулахад та бүхнийг эерэг үүргээ гүйцэтгэнэ гэж найдаж байна. Эцэст нь хэлэхэд IFAWPCA-ийн өнөөгийн энэ хүч чадал, нөлөө бүхий байгууллага бий болгоход чухал үүргийг гүйцэтгэсэн үе үеийн удирдлагуудад талархлаа илэрхийлье. Энэхүү IFAWPCA-ийн 46 дахь Чуулганыг өргөн хүрээнд зохион байгуулахад хүчин чармайлтаа гарган ажилласан одоогийн Ерөнхийлөгч, удирдах албан тушаалтнууд, нийт ажилтнуудад мөн давхар талархлаа илэрхийлье. Барилга, дэд бүтцийн салбарыг бэхжүүлэх зорилготой энэхүү чуулганыг амжилттай зохион байгуулж өндөрлүүлэхийг Та бүхэнд хүсэн ерөөе" гэж нээлтийн үгээ өндөрлөв.

"ЕРӨНХИЙ АССАМБЛЕЙ-I"-ээр IFAWPCA-ийн гишүүн орнуудын тэргүүнүүд нь өөрсдийн орнуудын "БАРИЛГЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ"-ын талаарх танилцуулгыг танилцууллаа. Тус танилцуулгыг буюу Монгол Улсын барилгын салбарын өнөөгийн байдал, барилгын салбарын сүүлийн 5 жилийн өсөлт, барилга угсралт их засварын ажил, бүтэц, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн өнөөгийн байдал, нийт хүн амын тоон мэдээлэл, салбарын дундаж цалин хөлс, мөн Монгол Улсад хэрэгжиж буй томоохон төслүүдийн талаарх танилцуулгыг МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Л.Хулан нь танилцууллаа.

Энэ өдрийн үдээс хойш нь IFAWPCA-ийн гишүүн орнуудын төлөөллүүд нь холбогдох **БАЙНГЫН ХОРООД** буюу буюу **ГИШҮҮНЧЛЭЛ, ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ, БАРИЛГЫН БИЗНЕС БА ХӨГЖИЛ,**

БОЛОВСРОЛ БА ХҮНИЙ НӨӨЦ, БАРИЛГАЧДЫН ШАГНАЛЫН ХОРООДОД хуваарилагдан барилгын салбарт тулгарч буй асуудлыг ярилцаж, шийдэл, шийдвэрийг гаргалаа.

МБҮА ТББ нь **“БОЛОВСРОЛ БА ХҮНИЙ НӨӨЦИЙН БАЙНГЫН ХОРОО”**-нд хуваарилагдаж, хурлаар IFAWPCA-ийн гишүүн орнуудын барилгын салбарын ажиллах хүчний асуудлын хүрээнд баримталж буй төр засгийн бодлого, салбарын ажиллах хүчний нөхцөл байдал, ажилчдын ур чадвар, цалин хөлс зэрэг мэдээллийг хоорондоо солилцов.

Хонг-Конгийн Барилгын Ассоциаци (HKCA): Тус улсын хувьд гадаадын ажиллах хүчийг оруулж ирэх бодлого дээр 1 төсөлд 12,000 ажиллах хүчийг авч ажиллуулах, 1 өдрийн цалинг 100-300 Хонг-конг доллар байхаар тогтоож байгаа. Мөн сүүлийн жилүүдэд хүн амын дунд насжилт их явагдаж байгаа нь барилгын салбар гэлтгүй бүх салбаруудад ажиллах хүчний хомсдол нэмэгдэж байгаа, Засгийн газраас гадаадын ажиллах хүчний цалин хөлсийг Хонг-конгийн ажилчдын цалингаас бага болон 1 хүнд ногдох хураамжийг 400 Хонг-Конг доллар байлгахаар тогтоосонтой холбоотой гэж үзэж байгаа болно.



Сингапурын Гэрээлэгчдийн Ассоциаци (SCAL): Тус улсад Ковидын өмнө гаднаас 380,000 ажиллах хүчийг авсан бөгөөд энэ тоон үзүүлэлт нь одоо 280,000 болсон байна. Ирэх онд ажиллах хүчний тоо дахиад буурч байгаа нь тус улсад хэрэгжиж байгаа төслүүд нь хойшлогдож байгаатай холбоотой болно. Тиймээс Засгийн газрын зүгээс нь Ажиллах хүчний бодлого дээр 2 том өөрчлөлтийг оруулж байгаа бөгөөд 1-т, нэг компани нь гадаадын ажиллах хүчийг 7-оос доошгүй байлгах, 2-т, техникийн экспертизийг шаардсан асуудал болно. Мөн тус улсын хувьд гол тавьж буй шаардлага нь ЧАДВАРЛАГ АЖИЛТНУУДЫГ авахыг илүүд үзэх болсон бөгөөд энэ нь ажиллах хүчний хомсдол гэхээсээ илүүтэйгээр тогтвортой ажлын байрыг бий болгож, салбарыг тогтвортой байлгахад хэрэгжүүлэх алхам гэж харж байна. Тус улсын компаниудын хувьд гаднаас ажиллах хүчийг оруулж ирэхэд өндөр татварыг төлдөг бөгөөд Гэрээлэгчдийн Ассоциаци нь Засгийн газартайгаа харилцан хамтран сайн ажилладаг байна. Сингапурын Хөдөлмөрийн яам нь гаднаас ажиллах хүчийг оруулж ирэх асуудал дээр маш өндөр шаардлагыг тавьдаг бөгөөд тухайн улс оронд нь Ажиллах хүчний агентлагийг байгуулж, хүмүүсийг эхлээд эх оронд нь сургасны дараа тусгай шалгалтаар шалгаруулан авч, түүний дараа нь Сингапур Улсаас тусгай комисс очиж дахин шалгалтыг авч сонгон шалгаруулж баталгаажуулдаг бөгөөд Сингапур Улсад ирснийх нь дараа дахин шалгалтыг авч сонгон шалгаруулж, хуваарилалтыг хийдэг шатлалтай болно. Энэ нь хүний наймааны асуудлыг үүсгэхээс урьдчилан сэргийлэхээс гадна шалгуурт нийцээгүй ажилчдыг очихоос хамгаалсан арга юм байна. Учир нь тухайн ажиллах хүчин нь асар их хэмжээний өр шир тавьж Сингапур Улсад ирэх, тэгээд энэ өр ширээ хурдан төлөх гэж сэтгэл санааны дарамтад орох зэрэг асуудлуудтай улбаатай болно.

Филиппиний Барилгын Ассоциаци (PCA) Тус улс ч мөн ялгаагүй ажиллах хүчний хомсдолтой байгаа. Засгийн газартаа техникийн чиглэлийн мэргэжилтнүүдийг нэмэгдүүлэх асуудал дээр анхаарал хандуулж эхэлж байгаа бөгөөд төгсөгчдөд NATIONAL COMPETENCY CERTIFICATE буюу УР ЧАДВАРЫН ҮНДЭСНИЙ ГЭРЧИЛГЭЭГ олгосноор цалинг нь нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлдэг байна. Мөн тус улсад нэг ажлаас нөгөө ажил руу шилжих хөдөлгөөн их явагдаж байгаа учир энэ тал дээр ч бодлого боловсруулах шаардлагатай байгаа талаар дурдав.

Шри-Ланкийн Барилгын Үндэсний Ассоциаци (NCASL): Тус улс нь ч ялгаагүй хүнээ сургах асуудал дээр маш их анхаарал хандуулж байгаа. Тиймээс ч сардаа 300 гаруй хүнийг сургалтад хамруулж, ур чадваргүй ажилчдыг сургаж байна. Энэ хүрээнд Гишүүн орнуудын зүгээс хүсэлт ирүүлэх юм бол сургалтын талаарх бүх мэдээллийг явуулж болно гэдгээ илэрхийллээ.



Индонезийн Гэрээлэгчдийн Ассоциаци (ICA): Тус улсын хувьд өнөөдрийн байдлаар хөдөлмөрийн зах зээлд нь 100,000 сая гаруй ажиллах хүчин ажиллаж байна. Ер нь бол ажиллах хүчний эрэлт ба нийлүүлэлтийн харьцааг тэнцвэртэй болгох хэрэгтэй байгааг дурдаж байв.

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци (MNCA): Монгол Улсад ч мөн адил барилгын салбарт ажиллах хүчний хомсдол бий болж Япон, Солонгос, АНУ, Канад руу их гарч ажиллаж байгаа. Иймээс Индонез Улсын хэлж байгаачлан ажиллах хүчний эрэлт ба нийлүүлэлтийн судалгааг IFAWPCA-ийн гишүүн орнуудын дунд нэгдсэн платформыг бий болгож үүнээс мэдээллээ авч аль улсад, ямар ур чадвартай, хэдий хэмжээний ажиллах хүчин хэрэгцээтэй байгаа, хэрхэн үүнийг IFAWPCA-ийн гишүүн орнуудын хувьд хоорондоо уялдуулж хамтран ажиллах, Засгийн газрын зүгээс гадаадын нэг ажиллах хүчинд ногдох хураамж зэргийг нэгтгэсэн маягтыг бий болгон мэдээллээ солилцох нь чухал буй талаар саналаа хэллээ.

Тус хурлын үр дүнд IFAWPCA-ийн Гишүүн орнуудын хувьд бүхий л орнуудад ажиллах хүчний асуудал байгаа тул бүгд өөр өөрсдийн орнуудын ажиллах хүчний бүхий мэдээллүүдийг нэгтгэсэн нэгдсэн мэдээллийн “ПЛАТФОРМ”-ыг үүсгэснээр “Ажиллах хүчний эрэлт ба нийлүүлэлтийн судалгаа”-г гарган аль оронд илүүдэлтэй, хомсдолтой байгааг тодорхойлох асуудлыг хамтран шийдэж, бодит байдлаар энэ асуудал дээр ажиллах шаардлага байгаа, ирэх 2024 онд ур чадвартай мэргэжилтэй ажилтныг бэлтгэх онлайн сургалтуудыг Шри-Ланк, Индонез, Сингапур, Филиппин улсууд улирал тутам нэг нэгээрээ явуулах саналыг дэвшүүлснээр эдгээр асуудлууд батлагдав. Харин сургалт хүсэж буй улс орнууд нь ямар сэдвээр сургалт авах тухайгаа ирүүлж болно гэдгийг эцэст нь дурдсанаар хурал олон чухал санаа санаачилгыг гаргаснаар амжилттай өндөрлөв.

Дараагийн өдөр нь **“ТОГТВОРТОЙ ДЭД БҮТЦИЙН ТҮНШЛЭЛ ФОРУМ”** зохион байгуулагдаж, тус форумаар IFAWPCA-ИЙН гишүүн орнууд нь “ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ НОГООН ДЭД БҮТЦЭД ЧИГЛҮҮЛЭХ”-ээр боллоо. Хүний хэрэгцээ, хүсэл эрмэлзлийг хангахад шаардлагатай байгаа дэд бүтцийг бий болгохын тулд дэлхий нийтээрээ асар их хөрөнгө оруулалтыг хийж байна. Тооцоо судалгаагаар дэлхийн хэмжээнд 2050 он хүртэл дэд бүтцийн салбарт жил бүр 9.2 их наяд ам.долларын зардлыг гаргах шаардлагатай байгаа буюу бараг 3/4 нь шинэ бүтээн байгуулалтад зарцуулагдаж байна. Ази, номхон далайн бүс нутаг нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, тогтвортой хөгжлийг бий болгохын төлөө ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтыг хийсэн, хамгийн хурдацтай хөгжиж буй бүс нутгийн нэг юм. Азид л гэхэд эдийн засгийн өсөлтийн хурдыг хурдасгах, ядуурлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг бууруулахад 2030 он хүртэл зөвхөн дэд бүтцийн салбарт жил бүр 1.7 их наяд ам.доллар шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, барилга байгууламжийн бүтээн байгуулалт, ашиглалт нь дэлхийн хүлэмжийн хийн ялгаруулалтын 40 орчим хувийг, барилгын материалын үйлдвэрлэл, худалдан авалт, ашиглалт, засвар үйлчилгээ, нураалт, хог хаягдлыг боловсруулах үеийн нийт хог хаягдлын бараг 1/3-ийг эзэлж байна. Иймд бид цаашид энэ тал дээр үр ашигтай бодлогыг хэрэгжүүлэхгүй бол хүлэмжийн хийн ялгаруулалт нь байгаль орчин болон барилга байгууламжид нөлөөлнө гэсэн тооцоо байна. Өөрөөр хэлбэл, бидний барьж байгаа байшин барилга, дэд бүтэц нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд тэсвэртэй, хүлэмжийн хийг хамгийн бага хэмжээгээр ялгаруулах ёстой байхыг шаардаж байна. Иймээс IFAWPCA-ийн гишүүн орнууд нь энэхүү чуулганаараа ногоон дэд бүтэц, тогтвортой хөгжилд чиглэсэн үйл ажиллагааг явуулахыг уриалж, гол чиглэлээ болголоо. Мөн “ЗАЛУУ ЛИДЕРҮҮД”-ийн хөтөлбөрийг зохион байгуулж салбарын ирээдүйн лидерүүдийг төрүүлэх, хамтран төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг асуудлыг хөндөв.

Тус форумын дараа **УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ-II-**аар Байнгын хороодын буюу Гишүүнчлэлийн, Гэрээний нөхцөлийн, Барилгын бизнес ба хөгжлийн, Боловсрол ба хүний нөөцийн, Барилгачдын шагнал гардуулах Байнгын хороодын хурлуудыг хуралдуулж, хороо тус бүрд Гишүүнчлэлтэй улс орны төлөөллүүд нь өөрийн улсын барилгын салбарт хэрэгжиж буй гэрээний нөхцөлд тулгарч буй асуудал, барилгын бизнесийг хэрхэн өргөжүүлэх, харилцан хамтын ажиллагааг яаж бий болгох, барилгын салбарт үүсээд буй хүний нөөцийн хомсдол, ажилчдыг чадваржуулах, тэднийг хэрхэн сургах, эдгээр асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар харилцан санал бодлоо солилцож, туршлагаа хуваалцлаа.

Тус хурлын төгсгөлд 2023-2025 он хүртэл ажиллах Удирдах зөвлөлийн гишүүдийг баталж, IFAWPCA-ийн 2023-2024 оны хүндэт гишүүдийн асуудлыг хэлэлцэн тогтлоо.



Сүүлийн өдөр **ЕРӨНХИЙ АССАМБЛЕЙ-I** хурлаар IFAWPCA-ийн үүсэл хөгжил, хөгжлийн үе шатны талаар танилцуулга хийгдэж, улмаар IFAWPCA-ийн 46 дахь Ерөнхийлөгч Раби Сингх арга хэмжээг нээж үг хэлэв. Тус Ассамблейгаар Мальдив-д зохион байгуулагдсан 45 дахь Чуулганы үйл ажиллагааны тоймыг сайшаагаад, IFAWPCA-ийн Үндсэн хууль, протоколд нэмэлт өөрчлөлтийг оруулсныг танилцуулав. Энэ хурлаар IFAWPCA-ийн зарим гишүүн орнуудын Ерөнхийлөгчдийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, улмаар IFAWPCA-ийн гишүүн орнуудын төлөөлөгчдийн барилгын салбар дахь нөхцөлийн талаарх илтгэлүүдийг сонслоо.

ЕРӨНХИЙ АССАМБЛЕЙ-II хурлаар IFAWPCA-ийн гишүүн орнуудын онцлох илтгэлийг тавьснаар хурлыг эхлүүлж, 2023-2025 онд IFAWPCA-ийн Удирдах зөвлөлийн гишүүнд дэвшиж буй нэр дэвшигчид, 2023-2024 оны IFAWPCA-ийн Хүндэт гишүүнд дэвшиж буй нэр дэвшигчдийг батламжиллаа. Мөн Ассамблейгаар IFAWPCA-ийн САЛБАРЫН ШАГНАЛ, ЧУУЛГАН-д 5,10,15 УДААГААС ДЭЭШ ИДЭВХТЭЙ ОРОЛЦСОН ГИШҮҮН ОРНУУДЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ШАГНАЛ болон IFAWPCA-ийн 45 дахь Чуулганыг зохион байгуулсан Мальдивын Барилгын Үйлдвэрийн Үндэсний Холбоо (MNACI)-ны Ерөнхийлөгч Мохамед Али Жанад шагнал гардууллаа. Тус Ассамблейн хамгийн гол үйл явдал болох IFAWPCA-ийн 2023-2025 он хүртэл ажиллах Удирдах зөвлөлийн гишүүдийг тангаргийг өргүүлэх ёслолуудыг хийлээ. Эцэст нь IFAWPCA-ийн 46 дахь Чуулганыг Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улсад зохион байгуулсны дараа IFAWPCA-ийн 47 дахь Чуулганыг зохион байгуулах улсаар Сингапур Улсын Барилгын Ассоциаци сонгогдож, тус Ассоциацийн Ерөнхийлөгч асан **КЕННЕТ ЛУ** нь **IFAWPCA-ИЙН 47 ДАХЬ ЕРӨНХИЙЛӨГЧ**-өөр сонгогдож, IFAWPCA-ийн 46 дахь Ерөнхийлөгч, Балба Улсын Барилгачдын Ассоциациудын Нийгэмлэгийн Ерөнхийлөгч РАБИ СИНГ нь арга хэмжээг хааж үг хэлэн ёслол төгөлдөр өндөрлүүллээ.





ОН ЦАГИЙН ТОВЧОО ЭРГЭЖ, IFAWPCA-ИЙН 47 ДАХЬ ЕРӨНХИЙЛӨГЧ КЕННЕТ ЛУ нь ажлаа хүлээн авсан эхний өдрөө “УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ШИНЭ ГИШҮҮДИЙН ХУРАЛ”-ыг зохион байгуулж, Нээлтийн үгэндээ тэрээр: “IFAWPCA-ийн гишүүн орнуудад энэ нэр төртэй албан тушаалд итгэл хүлээлгэж сонгосонд талархлаа илэрхийлж, өөрийн итгэл зүтгэлээ дайчлан ажиллана” гэдгээ илэрхийллээ. Энэ хурлаар өмнөх хурлаас гарсан асуудлууд, захиргааны шинэ ажилтнуудыг томилох, 2024 оны баталсан төсөвтэй танилцаж зарим тодотголыг оруулах, IFAWPCA-ийн дараагийн 43 дахь Дунд хугацааны хурлыг товлох, 47 дахь Чуулганыг хэрхэн зохион байгуулах болон 48, 49 дахь Чуулгануудын товыг тогтоох, Чуулганы зохион байгуулах ОН ЦАГИЙН ЭРГЭЛТ дуусаж байгаа зэрэг асуудлуудыг хөндлөө. Ийнхүү IFAWPCA-ийн Чуулганууд болон Дунд хугацааны чуулганууд нь IFAWPCA-ийн 18 гишүүн улс орнуудад ээлжлэн зохион байгуулагдаж буй нь дэлхийн хаана ч амьдарч байсан бид нар нь нэгэн агаараар амьсгалж, нэгэн дээвэр дор багтан амьдарч байгаа тул салбарын хөгжлийг ногоон дэд бүтцэд чиглүүлж, байгаль орчинд ээлтэй техник, технологийг ашиглан эдийн засгийн өсөлтийг хангаж ажиллах нь илүү чухал ая холбогдолтой гэдгийг бусад улс орнууд болон салбарынхандаа ойлгуулахад анхаарлаа хандуулж байгаагаа тунхаглан харуулж байна.